



ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ХЭРЭГСЛЭЭР МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ СПОРТЫН АРБИТРЫН БОЛОН ДОПИНГИЙН ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫГ МЭДЭЭЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын болон допингийн Давж заалдах комиссын хуралдааныг мэдээлэх харилцааг энэ журмаар зохицуулна.
- 1.2. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ, Допингийн эсрэг үндэсний дүрэм, Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, допингийн Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон бусад хууль тогтоомжид энэ журам нийцсэн байна.
- 1.3. Энэ журмыг хэрэгжүүлэхдээ хүний эрх, эрх чөлөө, нэр төр, ажил хэргийн нэр хүнд, аюулгүй байдал, хувь хүн, гэр бүл, төр, байгууллагын хуульд заасан нууцыг хамгаалах, хуралдааны дэгийг сахих, олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй, хуралдаан нээлттэй байх зарчмыг баримтална.
- 1.4. Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон допингийн Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрэмд заасны дагуу хуралдааны дуу авиа, дүрс бичлэг хийх, тэдгээрийг архивлах харилцаанд энэ журам хамаарахгүй.
- 1.5. Хууль тогтоомж болон энэ журамд зааснаас бусад үндэслэлээр хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчийн мэдээлэл олж авах, бэлтгэх, түгээх үйл ажиллагаанд хязгаарлалт тогтоохыг хориглоно.

Хоёр. Нэр томьёоны тодорхойлолт

- 2.1. Энэ журамд заасан дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
 - 2.1.1. "хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуралдааныг мэдээлэх" гэж хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын болон допингийн Давж заалдах комиссын хуралдааны танхимд тусгай төхөөрөмжөөр гэрэл зураг авах, бичлэг хийх, олон нийтэд нэвтрүүлэх ажиллагааг;
 - 2.1.2. "хэвлэл мэдээллийн байгууллага" гэж сонин, сэтгүүл, радио, телевиз, цахим хуудас, тэдгээрийн сүлжээ зэрэг мэдээлэл дамжуулах чиг үүрэгтэй аливаа этгээдийг;
 - 2.1.3. "хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан" гэж 2.1.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг иргэнийг;

- 2.1.4. "гэрэл зураг авах" гэж аливаа аргаар дүрс хуулбарлахыг;
- 2.1.5. "бичлэг хийх" гэж хуралдааны явцыг дуу болон дүрсээр хадгалахын тулд аливаа аналог болон дижитал төхөөрөмж ашиглахыг;

Гурав. Арбитрын болон Комиссын хуралдааныг мэдээлэх

- 3.1. Арбитр, Комиссын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж буй хуралдааныг хэвлэл мэдээллийн байгууллагын бичгээр гаргасан хүсэлтийн дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр бүрэн эсхүл хэсэгчлэн мэдээлэхийг зөвшөөрөх, татгалзах, түүнийг хязгаарлах, дуусгавар болгох асуудлыг Бүрэлдэхүүн шийдвэрлэнэ. Хуралдааныг нээх, шийдвэр уншиж сонсгох хэсэг нь холбогдох олон улсын гэрээ, олон улсын стандарт болон хууль тогтоомжид заасны дагуу нээлттэй байна.
- 3.2. Бүрэлдэхүүн хуралдааныг олон нийтэд мэдээлэх тухай хэвлэл мэдээллийн байгууллагаас бичгээр гаргасан хүсэлтийг шийдвэрлэхдээ дараах хүчин зүйлийг харгалзан үзнэ.
 - 3.2.1. Арбитрт итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх;
 - 3.2.2. Арбитрын ил тод, нээлттэй байдлыг хангах;
 - 3.2.3. Хэрэг, маргааны талуудын саналыг хүндэтгэх;
 - 3.2.4. Урьдчилан сэргийлэх ач холбогдолтой байх;
 - 3.2.5. Бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангах;
 - 3.2.6. Хуралдааны танхимын багтаамж;
 - 3.2.7. Хүртээмжтэй мэдээлэл хүргэх бололцоо;
- 3.3. Хуралдааныг мэдээлэхдээ дараах журмыг баримтална.
 - 3.3.1. Хэвлэл мэдээллийн байгууллага хуралдааны энэ журмын 3.1-д зааснаас бусад хэсгээс мэдээлэл бэлтгэх хүсэлтийг хуралдаан товлогдсон өдрөөс ажлын арваас доошгүй хоногийн өмнө Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитртын Ажлын алба (цаашид “Ажлын алба” гэх)-д гаргана.
 - 3.3.2. Ажлын алба хэвлэл мэдээллийн байгууллагаас ирүүлсэн хүсэлтийг Бүрэлдэхүүнд танилцуулахын өмнө энэхүү журмыг хүсэлт гаргасан этгээдэд танилцуулж баталгаажуулна. Танилцуулсан баталгааг хүсэлтэд хавсарган Бүрэлдэхүүнд хүргүүлнэ.
 - 3.3.3. Ажлын алба хэвлэл мэдээллийн байгууллага, ажилтантай гэрээ байгуулна. Ажлын алба гэрээнд Бүрэлдэхүүн, Бүрэлдэхүүний аюулгүй байдал, хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, арбитрт нөлөөлөх аливаа оролдлогоос сэргийлэх, арбитрт итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулахгүй байх, дуу, дүрс бичлэгийг өөр зориулалтаар ашиглахгүй байх, түүнийг хэзээ, хэрхэн устгах, харилцан хүлээх эрх, үүрэг, хариуцлага зэргийг тусгана.
 - 3.3.4. Хуралдааны танхимд гэрэл зураг, дуу-дүрсний бичлэг хийх төхөөрөмжийг зөвхөн Бүрэлдэхүүн, хуралдааны оролцогчдын дүрс харагдахуйц хэсэгт хөдөлгөөнгүй байршуулна. Хуралдааны хувь хүний нууц, төрийн болон албаны нууц болон оролцогчдын аюулгүй байдлыг хангах үүднээс Бүрэлдэхүүн даргалагч, Бүрэлдэхүүн гэрэл зураг авах, дуу-дүрсний бичлэгийг зогсоож болно.

- 3.4. Хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхэд дараах зүйлийг хориглоно.
- 3.4.1. Хувь хүний нууц, Төрийн болон албаны нууц, ёс суртахуун, нийтийн хэв журам, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхол, насанд хүрээгүй хүмүүсийн ашиг сонирхол, талуудын хувийн нууцыг хамгаалах шаардлагатай тохиолдолд, нийтэд мэдээлэх нь тэдгээрийн эрх ашигт хохирол учруулах бол эсвэл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь зөвхөн хуулийн асуудалтай холбоотой тохиолдолд;
- 3.4.2. Бүрэлдэхүүний хараат бус, бие даасан байдлыг алдагдуулах мэдээ, мэдээлэл гаргах;
- 3.4.3. Хуралдааны зөвшөөрөгдсөн хэсгийг дамжуулахдаа танхим дахь бусад хүмүүсийн дүрсийг харуулах;
- 3.4.4. Хуралдааны дэгийг зөрчсөн аливаа үйлдэл гаргах;
- 3.4.5. Бүрэлдэхүүний тогтоосон болон энэ журамд заасан хязгаарлалтыг зөрчих;
- 3.4.6. Шийдвэр эцэслэн гараагүй байхад урьдчилан мэдээлэх;
- 3.4.7. Хуралдааны бичлэгийг хуулбарлан бусдад тараах, дуу, дүрс бичлэгт эвлүүлэг хийх, хэсэгчлэх, аливаа сурталчилгаанд ашиглах;
- 3.4.8. Бүрэлдэхүүнээс ярилцлага авах;
- 3.5. Ажлын албанаас хуралдааны явц, шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлчид мэдээлнэ. Хуралдааны тойм мэдээллийг тухай бүр арбитрын цахим хуудсаар мэдээлнэ.
- 3.6. Хуралдааны явц, шийдвэрийн талаар хэвлэлийн бага хурал зохион байгуулж болно.
- 3.7. Хуралдааны явц, шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, нийгмийн сүлжээгээр гарсан мэдээлэлд нарийн бичгийн дарга тухай бүр хяналт-шинжилгээ хийж Ажлын алба, Бүрэлдэхүүнд танилцуулна.
- 3.8. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр хуралдааны явц, шийдвэрийн талаар ташаа мэдээлэл гарсан тохиолдолд Ажлын алба залруулж, бодит мэдээллийг өгнө. Энэ мэдээллийг арбитрын цахим хуудаст нийтэлсэн байна.
- 3.9. Ажлын албанаас хуралдааны явц, шийдвэрийн талаарх мэдээлэл өгөхөд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч мэдээ бэлтгэхийг хязгаарлах, шийдвэрийн үндэслэлийг тайлбарлах, Бүрэлдэхүүн болон хэргийн оролцогчдын талаар өөрийн байр суурийг илэрхийлэхийг хориглоно.

Дөрөв. Бусад

- 4.1. Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын дүрэм, хэрэг хянан шийдвэрлэх дүрэм, допингийн Давж заалдах комиссын дүрэм болон түүний хэрэг хянан шийдвэрлэх дүрмээр тус тус зохицуулна.
- 4.2. Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомж болон бусад дүрэм, журамд заасан хариуцлага хүлээлгэнэ.
- 4.3. Энэхүү журам нь Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын болон допингийн Давж заалдах комиссын үйл ажиллагаанд мөрдөгдөнө.